

Компанийн засаглалын журмууд шинэчлэн
батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх хорооны 2025 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 2025/03 тоот зөвлөмж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн засаглалын кодексийн зорилгод нийцүүлэн Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журамыг нэгдүгээр хавсралтаар, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх хорооны журмыг хоёрдугаар хавсралтаар, Залгамж халааны бодлогыг гуравдугаар хавсралтаар, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны зааварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тогтоолын Хоёр, Дөрөвдүгээр хавсралт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/12 тоот тогтоолын Хоёрдугаар хавсралт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 2022/35 тоот тогтоолын Хоёрдугаар хавсралтыг тус тус хүчингүй болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, журмын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хороод, гишүүд, Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар) нарт үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын Хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.ГАНЗОРИГ





КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 7 сарын 24-ний өдөр

№ 2025/34

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх
Цалин урамшууллын хорооны журмыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны 2025 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 2025/01 тоот зөвлөмж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны журмыг тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, журмыг хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хороод, гишүүд, Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар) нарт үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын Хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ



КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 7 сарын 24-ний өдөр

Дугаар 2025/36

Улаанбаатар хот

Салбарын хаяг өөрчлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.14 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 7 сарын 24-ний өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард Кредит ББСБ” ХК-ийн БЗД, 9 хороо, Да хүрээ худалдааны төв, Автоцентр байрны Павилон 25 тоотод байрших Салбар-01 хаягийг Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо, Жуковын гудамж-1, Монгол шуудан байр болгон өөрчилсүгэй.
2. “Ард Кредит ББСБ” ХК-ийн СХД, 32 хороо, Авто худалдааны төв, МАКОС ХХК-ийн Автоком төвийн А блок, 3 давхар 308 тоот Салбар-03 хаягийг Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар хороо, Үйлдвэрчний эвлэлийн гудамж, 5 шар, Монгол шуудан өөрийн байр болгон өөрчилсүгэй.
3. Салбаруудын хаягийн өөрчлөлтийн зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авах, холбогдох өөрчлөлтийг Улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ